

ИРГЭДИЙН УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО БА ТҮҮНД НӨЛӨӨЛЖ БУЙ УЛС ТӨРИЙН ХҮЧИН ЗҮЙЛС

У.Батцэрэн

*Доктор (Ph.D) Удирдлагын академи. Төрийн алба, удирдлагын сургууль,
ШУА. Философийн хүрээлэн. Улс төр, эрх зүйн судлалын салбар.*

Түлхүүр үг: *Иргэний нийгэм, иргэдийн улс төрийн оролцоо, шууд ба төлөөллийн ардчилал, улс төрийн нам, улс төрч, сонгууль.*

Товч утга: Монголчууд бол төрт ёсны түүхэн уламжилтай ард түмэн билээ. Улс төрийн амьдралын өнөөгийн ардчилсан тогтолцоонд иргэдийн оролцоогүйгээр ардчиллын мөн чанарыг илэрхийлэх боломжгүй юм. Иргэдийн улс төрийн оролцоо: *иргэдээс төрийн байгууллага түүний бодлого, шийдвэр, үйл ажиллагаанд нөлөөлөх үйл явц юм.* Ардчилал оршихуйн суурь үндэс нь иргэдийн улс төрийн оролцоо байдаг. Иргэд ардчилалд болон улс төрийн шийдвэр гаргах үйл явцад бодитой оролцохын хэрээр ардчилал улам бүр баталгаажин төлөвшинө гэж үздэг. Монгол Улс иргэдийн улс төрийн оролцоог Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн түвшинд улс төр, эрх зүйн хувьд баталгаажуулж, түүний суурь үндсийг нэгэнт бүрдүүлсэн билээ. Гэвч бодит байдал дээр иргэдийн улс төрийн оролцоо сул оршоор байна. Үүний гол учир шалтгаан нь түүнд нөлөөлөх хүчин зүйлс тэр дундаа улс төр, хууль, эрх зүй, нийгэм, эдийн засгийн үзэл санаа төдийлөн хангалтай түвшинд байж чадахгүй мөн түүнд тулгарч буй бэрхшээлтэй асуудлууд ч байна. Иймээс өнөөгийн ардчилсан нийгэмд иргэдийн улс төрийн оролцоог боловсронгуй болгох нь зүй ёсны шаардлага үүсэн гарч байна.

Монгол Улсын хувьд иргэдийн улс төрийн оролцооны асуудал их онцлогтой. ХХ зууны эхэн хүртэл хаант засагтай байж байгаад коммунист тогтолцоонд шилжиж улмаар 1990-ээд оноос иргэдийн улс төрийн оролцоо гэсэн ойлголт бий болж эхэлсэн. Төрийг бурханчилан шүтэж ойлгодог, төрийн минь сүлд өршөө, төрийн минь хишиг хэмээн залбирч ирсэн ард түмэн. Тиймээс ч иргэдийн оролцоо гэдэг ойлголт бараг байхгүй байсан гэж хэлж болох юм.

Иймээс Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэнгийн Улс төр судлалын салбараас “*Монгол Улс дахь төлөөллийн ардчилал ба иргэдийн улс төрийн оролцоо*” сэдэвт суурь судалгааны төслийн хүрээнд шинжээчийн санал асуулгын судалгааны үр дүнд үндэслэн дээрх сэдвийн хүрээнд тухайн асуудлыг авч үзэхийг зорив.

Summary: Mongolians is a nation with a long traditions history of statehood. The present democratic system of political life cannot manifest the nature of democracy without the civic participation. Citizens’ political engagement is a process that affects organizations, policies, decisions and activities. The basis of democracy is the participation of citizens. As democracy and political decision-making have emerged, citizen perceptions of democracy can be further strengthened. a legal basis for political participation in Mongolia has established in the Constitution and other legislative and political documents. However, in practice the political participation of citizens the people is low. The main reason for this is that political, legal, social and economic conceptual framework is not yet sufficiently developed. Therefore, the development of political participation of citizens in democratic societies has emerged as an acute necessity.

In Mongolia, political participation of citizens is very important. The category of political participation of citizens was almost unknown in our political science until 1990’s. From the beginning of the 20th century, when has been Bogdo-khan’s governance and during almost all

twentieth century when the communist regime has governed in the society the people was used to worship and therefore, citizens' voluntary involvement in civil affairs was almost impossible.

Therefore, Department of Political Studies of Institute of Philosophy (Mongolian Academy of Sciences) has conducted a comprehensive expert survey on "Representative Democracy and Political Participation in Mongolia". The article is based on the findings of this study.

Монгол Улс дахь иргэдийн улс төрийн оролцооны түүхийг товч авч үзвэл: 1921оны хувьсгалын үр дүнд төрийн хэргийг бүх нийтээр хэлэлцэж, бодлогоо тодорхойлох ардчилсан төрийн чиг үүрэг бүхий байгууллагын үндэс суурь тавигдсан бөгөөд анх удаасонгуулийг зохион явуулсан. 1924оны 11сарын 26-нд батлагдсан ббүлэг50 зүйлтэй,1940оны бсарын30-нд батлагдсан, 10бүлэг99 зүйлтэй, 1960онд батлагдсан10бүлэг 94 зүйлтэй эдгээр хуулиудыг тухайн цаг үе нийгэмтэйгээ холбогдуулан иргэдийн оролцооны асуудлыг тусган батлан гаргаж улмаар 1949, 1963онуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Дээрх 3 удаагийн үндсэн хууль дахь иргэдийн оролцооны талаарх нийтлэг зүйл заалтуудын хувьд иргэдийн улс төрийн оролцооны талаарх ойлголт дараах бадлаар тусгагдсан байна. Үүнд:

- 18 нас хүрсэн иргэн бүхэнд эрэгтэй, эмэгтэй, шашин шүтлэг, үндэс угсаа ялгаварлахгүйгээр (гагцхүү шүүхийн тогтоолоор ял идлэж байгаа иргэдээс бусад нь) сонгох сонгогдох эрх эдлэх;
- Улсын Их Хурлын гишүүнийгсонгохдоо иргэд шууд, тэгш сонгуулийн эрхийг үндэслэж иргэд санлаа нууцаар өгөх;
- Төрийн бодлого шийдвэртэй холбоотойгоор ард нийтийн санал асуулга явуулах;
- Үг хэлэх, хэвлэн нийтлэх, хурал цуглаан хийх, жагсаал цуглаан хийхийг хуулиар батлан олгох;
- Эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдийн нэгэн адил тэгш эрхийг эдлэх гэх мэт.

Эдгээр зүйл заалтууд нь 1992оны Үндсэн хуулиар улам боловсронгуй болон хуульчилагдсан. 1921оноос хойшхи иргэдийн улс төрийн оролцоо нь нэгдэлжих, хөдөлгөөн, атрын аян,намын хурал зэргээр хязгаарлагдаж байснаас гадна төрийн үйл хэрэгт эмэгтэйчүүдийн оролцоо маш бага байсан нь бидний уламжлалт зан үйлтэй холбоотой.1951оноос эмэгтэйчүүдийн оролцоо нэмэгдсэн төдийгүй тэднийг зориудаар сонгуульд оролцуулж байсан.1990оныг хүртэл төрийн үйл явц дахь иргэдийн улс төрийн оролцоо нь төдийлөн бүрэн утгаараа хэрэгжиж чаддаггүй үндсэн хууль нь бэлгэдлийн шинжтэй, сонгуульд оролцох иргэдийн сонголт нь зөвхөн нэг намын төлөө албадан зохион явуулдаг хурал цуглаанд суусны үр дүнд сонголт хийдэг, массын нөлөө их нэгнээ даган дууриах явдал олонтоо тохиолддог байсан үүний нэгэн илрэл нь намын гишүүнээр элсэх, мөн нэгдэлжих хөдөлгөөнд элсээгүй хүнийг ухуулга сурталчилгаанд суулгах зэргээр илэрч байсан нь иргэдийн улс төрийн оролцоонд тулгарч буй бэрхшээлтэй асуудал төдийгүй ардчиллын үнэт зүйл, тухайн он жилүүдийн улстөрийн нөхцөл байдал иргэдийн оролцооны талаарх мэдлэг,мэдээлэл, ухамсар төлөвшиж төдийлөн чадаагүйтэй холбоотой юм.

Харин 1989оны сүүлч бол ард түмний хувьд өөрчлөлт шинэчлэлтийн түүхэн он жилүүд байлаа. Тухайлбал, тайван замаар жагсаал цуглаан зохион байгуулж, олон намын тогтолцооны үндсэн дээр бүх нийтийн чөлөөт ардчилсан сонгууль явуулан нам, төрийн үүргийг зааглах, улстөрийн тогтолцооны гол цөм нь төр байх түүний чиг үүргийг бүх талаар хангаж эрх хэмжээг нь өргөтгөх парламентын нэгдмэл тогтолцоог бүрдүүлж, ардчиллыг бүх талаар хэрэгжүүлж иргэдийг төрийн үйл хэрэгт оролцох нөхцөл боломжийг бүрэн утгаар нь хэрэгжүүлэх боломжийг олгосон. Эндээс дүгнэж үзэхэд 1921-1990 он хүртэлх иргэдийн улс төрийн оролцоо нь Үндсэн хуульд бэлгэдэл төдий нэг намын үзэл суртал, уламжлалт зан үйлийн хүчин зүйлсийн нөлөөн дор идэвхгүй байдлаар оршин байсан. Харин 1990 оны ардчилсан хувьсгал нь иргэдийн улс төрийн оролцоо үндсэн утгаараа хэрэгжих боломжтой болж иргэдийн мэдлэг ухамсарт эргэлт болж чадсан. Гэвч бид ардчилсан тогтолцоондшилжин иргэдийнулстөрийнэрх,эрхчөлөөгтунхаглаад20гаруйжилболсонболовч уламжлалтсэтгэлгээулс

төрд тодорхой хэмжээгээр хадгалагдсаар байна. Иргэдийн улс төрийн оролцоог хууль, тогтоомжийн түвшинд баталгаажуулж, түүний эрх зүйн суурь үндсийг нэгэнт бүрдүүлсэн боловч амьдрал дээр нийгэм, эдийн засаг, улс төр, хууль, эрх зүйн үзэл санаа тэр бүр бүрэн тодорхой хэрэгжиж чадахгүй байгаа нь бодитой баримт юм.

Энэ нь нэг талаараа иргэдийн улстөрийн оролцооны нэгэн гол бэрхшээлтэй асуудал юм. Нөгөө талаар иргэдийн улс төрийн оролцооны бэрхшээлтэй асуудал нь иргэдийн боловсрол, мэдлэг, мэдээллээр дутагдалтай байдал, нийгэм-эдийн засгийн хямрал зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой. Иймээс иргэдийн улс төрийн оролцоог боловсронгуй болгоход нэг талаас түүнд нөлөөлж болох хүчин зүйлс (нийгэм, улс төр, эрх зүй, эдийн засаг гэх мэт)-ийг судлах. Нөгөө талаас иргэдийн улс төрийн оролцоог боловсронгуй болгоход нэн тэргүүнд судлах асуудал бол түүнд нөлөөлж буй хүндрэл, бэрхшээл юм.

Манай Улсын хувьд улс төр, эрх зүй, эдийн засаг, иргэдийн боловсрол, мэдлэг болон үнэн бодит мэдээллээр хангагдах, иргэний нийгмийн байгууллагуудын төлөвшилээрэг нь иргэдийн улс төрийн оролцоонд нөлөөлж буй голлох бэрхшээлтэй асуудлууд болоод байна. Иргэдийн улс төрийн оролцоог боловсронгуй болгохын тулд эхлээд бэрхшээлтэй асуудлыг тодорхойлон гаргаж улмаар түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг томъёолон судлах явдал билээ. Иргэдийн улс төрийн оролцоонд нөлөөлж буй голлох бэрхшээлтэй асуудлууд нь тус хүрээлэнгийн Улс төр судлалын салбараас шинжээчдийн дунд явуулсан судалгааны эцсийн үр дүнгээр нотлож байна. Голлох бэрхшээлүүдийг товч авч үзвэл. Тухайлбал, улс төрийн намын төлөвшөөгүй байдал, улс төрийн хүрэн дэх эрх мэдлийн төлөөх тэмцэл, хуйвалдаан, улс орны эдийн засгийн нөхцөл байдал, улс төрчдийн авлига хээл хахууль, лобби, ёс зүйгүй байдалзэрэг бэрхшээлүүд нь судалгааны эцсийн үр дүнд өндөр хувьтай гарсан байна. Иргэдийн улс төрийн оролцоо талаас нь улс төрийн намуудын хөгжил, төлөвшлийг дараах *гурван үед* хуваан үзэж болох юм. Үүнд:

1. *1-р үе шат. (1921-1990)*: Нэг намын хатуу тогтолцооны үе. Энэ үед иргэдийн улс төрийн оролцоог зөвхөн төрийн эрх барьж буй нэг нам л шийдэж байсан. Өөрөөр хэлбэл, иргэдийн улс төрийн оролцоо нэг намын хяналтанд байсан.
2. *2-р үе шат. (1990-2012)*: Олон намын тогтолцооны үе. Энэ үед улс төрийн намуудын тухай хууль батлагдсан, улс төрийн намууд нийгэмд олноороо мэндэлсэн боловч иргэдийн улс төрийн оролцоог төдийлөн хагаж чадаагүй. Учир нь улс төрийн хүрээнд үүссэн олигархи бүлэглэлүүдийн эрх ашгийн зөрчилдөөн, авилга, хээл хахууль, тэдний улс төрийн соёл, боловсрол сул байгаа нь иргэдийн бухимдлыг ихээр төрүүлж улмаар намуудын төлөвшилд сөргөөр нөлөөлж энэ нь угтаа иргэдийн улс төрийн оролцоон дахь идэвхийг буруулсан.
3. *3-р үе шат. (2012-өнөөг хүртэлх)*: Намуудын үзэл баримтлал, төлөвшил дахин боловсрогдох үе. Ардчиллыг төлөвшүүлэх, нийгэмд олон ургалч ардчиллыг хөгжүүлэхэд улстөрийн намуудын гүйцэтгэсэн үүрэг их байсан боловч өнөө үед нийгмийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өөрчлөгдөн шинэчлэгдэх зайлшгүй шаардлага намуудын өмнө тулгарч байна. Учир нь ирээдүйн улс төрийн оролцоо сүүлийн жилүүдэд их буурсан төдийгүй улс төрийн намд итгэх итгэл нь улам бүр саармагжиж байна.

Улс төрийн намуудулс орныг ирээдүйд хөтлөх, хөгжүүлэх зүй ёсны үүрэгтэй билээ. Өөрөөр хэлбэл, иргэдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд намуудын дахин төлөвшил маш чухал юм. Өнөөгийн нийгэмд үйл ажиллагаа явуулж буй намууд: үзэл баримтлал, бүтэц зохион байгуулалт, намын дотоод ардчиллыг бэхжүүлэх, намын гишүүд болон дэмжигчдийн оролцоог нэмэгдүүлэх, намын бодлогошийдвэрийг анхан болон дунд шатны нэгж, байгууллагуудын оролцоотойгоор тодорхойлох, боловсон хүчнийг шилж сонгох үйл ажиллагаа шударга, нээлттэй байх, улстөрийн ёс зүй, мэдлэг боловсролыг иргэдэд түгээн таниулах зэргээг намын төлөвшилд тулгамдаж буй бэрхшээлтэй асуудлуудыг шийдэж болох юм. Иймд намууд цаашдын үйл ажиллагаандаа, нам нь төрийн төвшинд улсыг удирддаг институт гэдгээ гүнээ ухамсарлаж, төр, нийгмийг холбодог, иргэдэд үйлчилдэг, тэдний дуу

хоолой, ашиг сонирхлыг хангадаг буюу иргэдийн оролцоог улс төрд нэмэгдүүлэх үүргээ сайн биелүүлж ажиллах нь чухал юм.

Улс төрийн хүрэн дэх *улс төрчдийн төдийгүй төрийн албан хаагчдын дунд эрх мэдлийн төлөөх тэмцэл, хуйвалдаан, авилгал, лобби, ёс зүйгүй байдал* зэрэг нь иргэдийн улс төрийн оролоонд сөргөөр нөлөөлж буй өөр нэгэн голлох хүндрэл, бэрхшээл болоод байгаа нь өнөөгийн нийгэмд зайлшгүй шийдвэрлэх асуудал болоод байгаа билээ. Эрх мэдлийн төлөөх тэмцэл нь улс төрийн сонирхолын бүлгүүдийн дунд байх ёстой ардчилсан зүйл боловч манайд үйл ажиллагаа явуулж буй сонирхолын бүлэг тэр дундаа улс төрийн намуудын хувьд үүнийг буруугаар хэрэглэж улмаар энэ үзэгдэл нь төр, засгийн үйл ажиллагаанд шууд болон далд хэлбэрээр нөлөөлж байгаа нь иргэдийн итгэл, оролцоог шууд бууруулахад ихээхэн нөлөөлж байна.

Судалгааны дүнгээс үзэхэд манай улсад дээрх бэрхшээлүүд нь иргэдийн улс төрийн оролцоонд сөргөөр нөлөөлж байна. Иймээс бид дээрх бэрхшээлүүдийг даван гарахын тулд нэн түрүүнд иргэдийн улс төрийн мэдлэг боловсролыг нэмэгдүүлэх, улс төр, эдийн засаг, хууль эрх зүйн таатай орчин бүрдүүлэх, иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаа буюу төрд оролцох оролцоог нэмэгдүүлэх, хэвлэл мэдээллийн үнэн бодит, тэнцвэртэй мэдээллийг цаг алдалгүй иргэдэд хүргэж байх нь нэн чухал шаардлагатай байна. Мөн улс төрийн субъектүүдийн үйл ажиллагаа, олон нийтийг хамарсан үйл ажиллагаа зэрэгт иргэдийг идэвхтэй тантан оролцуулах болон төр, засгийн зүгээс иргэдийг зөвхөн сонгогч, сонгуульд оролцох оролцоогоор хангах бус төлөөллийн шат, шатны байгууллагад тэдний санал бодлыг хүргэх, шаардлагатай гэж үзвэл өөрийн санал өгч дэмжсэн төлөөллийн байгууллагын төлөөлөгчид хариуцлага хүлээлгэдэг байх тийм эрх зүйн орчныг бүрдүүлж өгснөөр иргэдийн улс төрийн оролцоонд нөлөөлж буй бэрхшээлийг тодорхой хэмжээн багасгах боломжтой юм. Хамгийн гол бэрхшээлтэй асуудал бол иргэд өөрсдийн идэвхи зүтгэлтэй байх асуудал юм.

Иргэдийн улс төрийн оролцоонд нөлөөлж буй улс төрийн хүчин зүйлс

Доктор Ц.Ганболд¹⁴³ “Иргэдийн улс төрийн оролцооны шинэ давалгаа” сэдэвт өгүүлэлдээ: *иргэдийн улс төрийн оролцоо бол ардчилал, иргэний нийгмийн толь мөн* хэмээн тодорхойлсон байдаг. Энэ нь өнөөгийн ардчилсан нийгэмд иргэдийн улс төрийн оролцоо ямар байх ёстойг илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл, иргэдийн улс төрийн оролцоог тодорхойлохдоо тухайн орны төр засаг нь хүний эрх, хуулийг хэр дээдлэж сахидаг, сайн засаглал, тунгалаг төртэй байх, иргэний нийгэмхэрбэхжсэн зэргийг харгалзан үздэг байна.

Улс төрийн оролцоог тодорхойлох болон боловсронгуй болгохдоот үүднөлөөлж буй *улс төр, эрхзүй, эдийн засаг, нийгэм, хэвлэл мэдээллийн* хүчин зүйлсийг судлан тодорхойлох нь зүйтэй гэж үзэж байна. Тухайлбал, иргэдийн улс төрийн оролцоог түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн үүднээс нь судлан дараах хоёр байдлаар тодорхойлж болно. *Өргөн утгаарнь*: улс төрийн шийдвэр гаргах, улс төрийн бодлогын хэрэгжилтэд оролцох түвшин, улс төрийн мэдээллээр хангагдах, улс төрийн хариу үйлдлийн түвшин, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаа, улс төрийн мэдээллийн эх сурвалж, нийгмийн сэтгэлзүй зэргээр дамжуулан улс төрийн оролцоог тодорхойлж болно. *Товч утгаар нь*: иргэдийн улс төрийн идэвхийн нөлөөгөөр тэдний хүсэн хүлээсэн зүйлийг төр засаг хийж хэрэгжүүлэх явдал юм.

Доктор Д.Баасансүрэн¹⁴⁴ “Иргэдийн улс төрийн оролцоо: судалгааны онол, арга зүй” сэдэвт өгүүлэлдээ: “Улс төрийн шинжлэх ухааны хүрээнд иргэдийн улс төрийн оролцооны асуудлыг олон талаас нь янз бүрийн онол, парадигмийн үүднээс судлан тайлбарладаг бөгөөд тэдгэрийг дурьдвал *нэгд*, улс төрийн үйл явцын үндсэн субъект болох бусдаас хараат бус чөлөөт иргэн, хувь хүний зүгээс өөрийн ашиг сонирхол, хэрэгцээ шаардлагыг хангахад чиглэсэн үйл ажиллагааг судлан тайлбарладаг рационал сонголтын онол *хоёрт*, улс төрийн

¹⁴³“Монголын улс төр асуудал, эрэл, шийдэл” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл. Ред: Ц.Ганболд. №2. Уб., 2011. 64 дэх тал.

¹⁴⁴“Философи эрхийн судлал”. ФХ. Боть №29. Уб., 2015. 200-201 дэх тал.

оролцооны сэдэл тэмүүлэл шалтгаан зэргийг судлан тайлбарладаг мотивацийн онол *суравт*, иргэдийн улс төрийн оролцоонд нийгэм-улс төрийн нөхцөл, нийгмийн тогтвортой байдал, улс төрийн институт зэргийн нөлөөллийг судлан тайлбарладаг нийгэм, хүчин зүйлийн онолын хүрээнд судалдаг” гэж дүгнэж хэлсэн байна.

Улс төрийг сонирхох иргэдийн сонирхолын түвшин харилцан адилгүй бөгөөд иргэдийн улс төрийн оролцоонд нөлөөлдөг билээ. Судалгааны үр дүнгээс харахад судалгаанд оролцсон шинжээчид *Таны бодлоор манайд олон түмний улс төрийн оролцоо ямар түвшинд байна вэ?* гэсэн асуултанд төдийлөн хангалтай бус гэж 67.5 хувь нь хариулсан бол хангалтгүй түвшинд гэж 20 хувь, хангалттай түвшинд байна гэж 12.5 хувь нь хариулсан байна. Энэхүү дүн нь өнөөгийн нийгэмд болж буй улс төрийн үйл явцыг иргэд хэрхэн сонирхож байна тэр хэрээр тэдний улс төрийн оролцоо болон түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн шинж байдлыг илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл, судалгаанд оролцсон шинжээчид иргэдийн улс төрийн оролцоонд нөлөөлдөг хүчин зүйлсийг дараах байдлаар томъёолон гаргасанг хүснэгт №1-т үзүүлвэл.

***Хүснэгт №1. Иргэдийн улс төрийн оролцоонд нөлөөлж буй хүчин зүйл.* (дундаж хувь)**

№	Хариулт	Дундаж хувь
1	Боловсрол	33.33
2	Соёл	24.97
3	Иргэний нийгмийн байгууллага	25.00
4	Авлига	33.36
5	Ёс зүй	25.00
6	Сонгуулийн оролцоо	25.00
7	Улс төрийн намын оролцоо, имиж	25.00
8	Улс төрийн лидерийн оролцоо, имиж	25.00
9	Улс төрийн тогтворгүй байдал	25.00
10	Улс төрийн ухамсар	25.00
11	Бизнес	24.97
12	Банк, санхүү	25.00
13	Татвар даатгал	25.00
14	Хөрөнгийн зах зээл	24.97
15	Эрх зүй	24.97
16	Хуулийн үйлчлэлийн чадамж	25.02

Эх сурвалж: “Монгол Улс дахь төлөөллийн ардчилал ба иргэдийн улс төрийн оролцоо”. Шинжээчдийн санал, асуулга судалгааны тайлан. Уб., 2016 он.

Иргэдийн улс төрийн оролцоонд нөлөөлж буй дээрх хүчин зүйлүүдийг дундаж хувиар нь бодож үзвэл авилга 33.36, боловсрол 33.33, хуулийн үйлчлэлийн чадамж 25.02, иргэний нийгмийн байгууллага, ёс зүй, сонгуулийн оролцоо, улс төрийн нам болон улс төрийн лидерийн оролцоо, имиж, улс төрийн тогтворгүй байдал, улс төрийн ухамсар, банк, санхүү, татвар даатгал зэрэг хүчин зүйлс 25.00, соёл, бизнес, хөрөнгийн зах зээл, эрх зүйн хүчин зүйлс

24.97 хувьтай үр дүнд харагдаж байна. Дээрх хүчин зүйлсээс өндөр хувьтай байгаа *авлига, боловсрол* нь иргэдийн улс төрийн оролцоонд хэрхэн нөлөөлж байгаа болон иргэдийн улс төрийн оролцоог боловсронгуй болгоход хэрхэн нөлөөлж болох талаар товч судлан үзэв. Үүнд:

Иргэдийн улс төрийн оролцооны талаарх чиг хандлагыг 1990 оноос хойш дараах гурван үед хувааж үзэж болох юм. *Нэгд:* иргэдийн оролцоог сонгууль, ардчилалтай холбон үзэж Үндсэн хуульд тунхагласан үе. Иргэдийн оролцоо зөвхөн сонгууль, санал, гомдол, ард иргэдийн санал асуулгаар хязгаарлагдсан байсан. Энэ нь 2003 онд манай улсад зохион байгуулагдсан ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын 5 дугаар хурлыг хүртэл явагдсан гэж болно. Тухайн үед ардчиллын төлөв байдал, чанар, иргэний байгууллагуудын төлөвшил, байдлын үнэлгээ хийгдэж үр дүнд нь төр иргэний харилцаа ба төрөөс иргэдийнхээ өмнө үйл ажиллагаагаа хариуцах чадвар сул байсан.

Хоёрт: иргэдийн улс төрийн оролцооны асуудал төр, засгийн түвшинд хэлэлцэгдэж иргэний нийгмийн байгууллагууд төлөвшиж ирсэн үе. Иргэдийн улс төрийн оролцооны талаарх судалгаа хийгдэж иргэдийг идэвхжүүлэх, оролцоог хангах санаачилгууд орон нутагт хэрэгжиж эхэлсэн. Мөн төр, засгийн зүгээс иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, боловсронгуй болгохоор Улсын Их Хурал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт иргэдийн улс төрийн оролцоонд төрийн болон төрийн бус байгууллагууд, албан тушаалтнууд дэмжлэг үзүүлэх. Энэ үед иргэний нийгмийн зөвлөл байгуулагдан ажиллаж эхэлсэн үе билээ.

Гуравт: иргэдийн оролцооны чиг хандлагын хөгжлийн үе. Өөрөөр хэлбэл, иргэний танхим нээгдэж үйл ажиллагаагаа эхлүүлсэнтэй холбож болно. Иргэд хууль боловсруулах, төр, орон нутгийн шийдвэрт нөлөөлөн оролцох үүрэгтэйг тунхаглан иргэдийн оролцоог улс төрд улам боловсронгуй болгох боломжийг бүрдүүлсэн.


Шинжээчдийн дунд явуулсан судалгааны үр дүн буюу иргэдийн улс төрийн оролцоонд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг дараах байдлаар нэгтгэн бүлэглэж болох юм. Үүнд: сонгуулийн оролцоо, улс төрийн намын оролцоо имиж, улс төрийн лидерийн оролцоо имиж, улс төрийн тогтворгүй байдал, улс төрийн ухамсар зэргийг нэгтгэн *улс төрийн хүчин зүйл*, бизнес, банк, санхүү, татвар даатгал, хөрөнгийн зах зээл зэргийг нэгтгэн *эдийн засгийн хүчин зүйл*, эрх зүй, хуулийн үйлчилгээний чадамж зэргийн нэгтгэн *эрх зүйн хүчин зүйл*, боловсрол, соёл, ёс зүй, авилгал болон бусад нийгмийн үзэгдлүүдийг нэгтгэн *нийгмийн хүчин зүйл*-д хамруулан үзэж болох бол *хэвлэл мэдээллийн хүчин зүйл*, *оюун санааны хүчин зүйл* түүнчлэн *иргэний нийгмийн байгууллага* нь иргэдийн улс төрийн оролцоонд нөлөөлж байдаг хүчин зүйл билээ. Оюун санаа, хэвлэл мэдээллийн хүчин зүйлс нь шинжээчдийн дунд явуулсан судалгаагаар тодорхойлогдож гарч ирээгүй ч гэсэн иргэдийн улс төрийн оролцоо, оролцоог боловсронгуй болгоход төр, засаг, нийгмийн талаар үнэн бодит мэдээлэл олж авахад голлон нөлөөлдөг хүчин зүйл юм.

Иргэдийн улс төрийн оролцоо нь үүдэл шалтгаан болсон үйл явдал, сөргөлдөөн зэрэг цаг үеийн элементүүдээс гадна хэсэг бүлгийг хамарсан байдал, институцийн нөхцөл байдлын хүрээ зэргээс хамааралтай байдаг нь ойлгомжтой. Иргэдийн улс төрийн оролцооны талаарх судалгааг хийхдээ дээрх үйл явдлын болон иргэдийн улс төрийн оролцоонд нөлөөлөгч хүчин зүйлүүдийг нийгэм, улс төрийн тогтолцоотой холбон судлах нь зүйтэй юм. Иргэдийг тодорхой нөхцөлд идэвхижүүлэх, эсвэл тэднийг улс төрд оролцох боломжыг бий болгох, гаргах нийгмийн өдөөлт, бололцооны асуудлыг авч үздэг. Эмпирик судалгааны үр дүнгээс үзвэл, улс төрийн оролцоонд шийдвэрлэх нөлөө үзүүлдэг хүчин зүйл нь бодьгал нөөц бололцоо гэдэг нь тогтоогдож байгаа бөгөөд энэ нь ердийн болон ердийн бус оролцооны аль алинд хамаатай байна. Боловсролын өндөр түвшин, хангалттай их орлого болон түүнтэй холбоотой байдаг нийгмийн байр суурь зэрэг нь нийгэм, улс төрийн үйл явцад оролцох иргэний оролцоонд нааштай нөлөөлдөг ажээ. Боловсролын түвшнээс хамаараад улс төрийн боловсрол, дүгнэж цэгнэх улс төрийн чадвар ба үйл ажиллагаа явуулах мэдлэг зэрэг нь бүрэлддэг бөгөөд нийгмийн дотор хамтран ажиллах чадварт нь шийдвэрлэх нөлөө үзүүлдэг байна. Иргэдийн улс

төрийн оролцооны түвшинг тодорхойлох бас нэг хүчин зүйл нь улс төрийн чиг баримжаа болон өөрийнхөө үйл ажиллагаагаар ямар нэгэн өөрчлөлт хийж чадна гэсэн мэдрэмж юм.

Хувь хүн аль нэг улс төрийн чиглэл хийгээд аль нэг намд татагдсанаа хэдийчнээ мэдэрч, түүндээ итгэх тусам улс төрийн болон нийгмийн өөрчлөлтийг илүүтэй сонирхдог нь түгээмэл үзэгдэл. Үүнээс гадна улс төрийн хувьд өөртөө итгэлтэй байх түвшин хэдийчнээ өндөр болох тусам тэр нь иргэний идэвхи зүтгэлд нааштай нөлөөлдөг ажээ. Иргэд өөрийн нөлөөлөх боломжид улам илүү итгэхийн зэрэгцээ улс төрийн систем нь гаднаас буюу иргэний нийгмээс орж ирэх нөлөө түлхэцийг хүлээн авахад бэлэн байх тусам оролцооны түвшин төдийчнээ өндөр байдаг. Өөрөөр хэлбэл, улс төрийн оролцоо гэдэг бол иргэдээс төрийн байгууллага, төрийн бодлого, шийдвэр, үйл ажиллагааг дэмжих болон тэдгээрт нөлөөлөхийн төлөө хийж буй үйлдэл юм. Бидний улс төрийн оролцоо төрд хандах уламжлалт хандлагаас ихээхэн хамаарч байдаг. Энэ нь шинжээчдийн дараах дүгнэлтээр нотлогдож байна. (График№1).

График№1. Улс төрийн хүчин зүйл. (хувь)



Эх сурвалж: “Монгол Улс дахь төлөөллийн ардчилал ба иргэдийн улс төрийн оролцоо”. Шинжээчдийн санал, асуулга судалгааны тайлан. Уб., 2016 он.

Дээрх судалгааны үр дүнгээс харвал улс төрийн ухамсар болон улс төрийн намын оролцоо, имиж нь иргэдийн улс төрийн оролцоонд байнга нөлөөлж байдаг гэж шинжээчдийн 47.5 хувь нь үзсэн бол улс төрийн лидерийн оролцоо, имиж нь 41.0 хувь байна. Харин улс төрийн тогтворгүй байдал, сонгуулийн оролцоо бага хувьтай байгаа боловч бусад иргэдийн улс төрийн оролцоонд нөлөөлж буй бусад хүчин зүйлүүд буюу үзүүлэлтүүдтэй харьцуулахад харьцангуй өндөр хувьтай байна. Дээрхээс дүгнэн өгүүлэхэд иргэдийн улс төрийн оролцоонд нөлөөлж байна, зарим талаараа нөлөөлж байна гэсэн үзүүлэлтүүдийг нэгтгэн дундаж хувийг нь гарган эрмэбэлэн үзвэл дараах үр дүн харагдаж байна. (Хүснэгт№2)

Хүснэгт№2. Улс төрийн хүчин зүйл. (дундаж хувь, эрэмбэ)

№	Хүчин зүйл	Дундаж хувь	Эрэмбэ
8	Улс төрийн лидерийн оролцоо имиж	46.2	1
7	Улс төрийн намын оролцоо имиж	45.0	2
6	Сонгуулийн оролцоо	42.3	3
9	Улс төрийн тогтворгүй байдал	42.3	4
10	Улс төрийн ухамсар	37.5	5

Эх сурвалж: “Монгол Улс дахь төлөөллийн ардчилал ба иргэдийн улс төрийн оролцоо”. Шинжээчдийн санал, асуулга судалгааны тайлан. Уб., 2016 он.

Улс төр дэх иргэн хүний оролцоо бол ардчилалын нэг үнэт зүйл, түүний мөн чанарын илэрхийлэл болдог учир иргэд идэвхитэй, сайн дурын үндсэн дээр, эзэн ёсоор оролцох хэрэгтэй. Энэ ч утгаар нь эрдэмтэн Gustave Ade Cosq “Иргэдийн оролцоо бол ардчиллын

оршин тогтнох, сүүлийн тулах цэг” хэмээн бичсэн байдаг. Дээрх хүснэгтээс харахад манай улсад иргэдийн улс төрийн оролцоонд улс төрийн лидер буюу улс төрчид ихээхэн нөлөөлж байдаг байна. Мөн улс төрийн намуудын нөлөөлөл өндөр хувьтай байна. Ардчилсан нийгэмд иргэний улс төрийн оролцоонд хөндлөнгөөс нөлөөлөх нь мэдээж буруу зүйл юм. Энэ нь өнөөдөр бидний хувьд тулгараад буй нэн түрүүнд шийдвэрлэвэл зохих асуудал буюу иргэдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд учирч буй хүндрэл бэрхшээл юм.

Манай улсын хувьд иргэдийн улс төрд оролцох оролцоо нь дутмаг байна. Энэ нь нэг талаас иргэдийн өөрийн улс төрдэх оролцооны идэвхи сул, нөгөө талаас хөндлөнгийн улс төрийн субъектүүд нөлөөлөл их байгаатай холбоотой бөгөөд харин иргэд эсрэгээрээ улс төрийн субъектүүдийн үйл ажиллагаанд оролцох оролцоо нь бидний өнөөдөр тулгамдаад буй нэгэн хүндрэл, бэрхшээлийн асуудал юм. Улс төрчид, улс төрийн намууд үүргээ биелүүлж иргэдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх болон боловсронгуй болгоход төдийлөн анхаарч ажиллахгүй байна.

Улс төрчид нийгмийн үүргээ биелүүлж зөв үнэлэмж тогтоож байж л бусдын хүндлэлийг хүлээдэг байна. Улс төрчид бол ард түмний сэтгэл санааны удирдагч байж нийгэмд зөв үнэлэмж тээх үүрэгтэй. Улс төрчид манай улс хөгжихгүй байгааг тогтолцооны гажиг гэж өөрсдөөсөө зайлуулж улмаар өнөөдөр Үндсэн хууль болон бусад органик хуульд өөрчлөлт оруулах талаар ярьж байна. Энэ нь нэг талаас нийгмийн хөгжлийн зүй тогтлоо дагаад өөрчлөгдөх ёстой боловч улс төрчдийн эрх ашгийг хамгаалахын тулд өөрчлөгдөх зүйл биш юм. Хууль бол нийгмийн харилцааг л зохицуулдаг. Харин зарчим, ёс суртахуун нийгмийг удирддаг. Ялангуяа улс төрчдөд зарчим, ёс зүй, ёс суртахууны үнэлэмж хуулиас хүчтэй үйлчлэх учиртай. Нийгмийг ёс суртахуун удирддаг учраас улс төрийн удирдагчид нийгмийг зөв замаар хэрхэн авч явах тухай ярьж, бодлого боловсруулж өөрөө ч зөв явах ёстой. Манай улс төрчдийн нийгэмд өгч байгаа дохио, тогтоож байгаа жишиг нь ерөнхийдөө л ёс суртахууны хэм хэмжээнээс давсан, хуулийг үнэгүйдүүлсэн үйлдлүүд байх.

Улс төрийн тогтвортой байдал иргэдийн улс төрийн оролцоонд мөн тодорхой хэмжээнд нөлөөлдөг нь дээрх хүснэгтээс харагдаж байна. Харин иргэд өөрийн оролцоо нь маш чухал юм. Өөрөөр хэлбэл, иргэдийн улс төрийн ухамсар шинжээчдийн үнэлгээгээр бага үзүүлэлтэй гарсан байна. Иймд бид цаашид иргэн бүрийг улс төрийн мэдэлэг боловсролтой болгох, улс төрийн амьдралд идэвхитэй оролцуулах, улс төрийн ухамсарыг нь төлөвшүүлэх нь зүйтэй юм. Өнөөгийн нийгэмд жирийн иргэдийн дунд улс төрийн оролцоог сонгуульд оролцох хэлбэр хэмээнд буруу ташаа ойлгох явдал нилээд гүй байна. Өөрөөр хэлбэл, манай улсад иргэдийн оролцоо нь ихэнхдээ сонгууль өгөхөд л илэрдэг. Сонгууль болоход бүх хүн саналаа өгч, идэвхтэй улс төрийн оролцоо болдог. Манай улс иргэний идэвхтэй нийцтэй оролцооны хэлбэрийг бүрдүүлж, иргэн хүн бүрийг идэвхтэй оролцуулах хэрэгтэй юм. Улс төрийн тогтолцоо нь ардчилсан шинжтэй байхын тулд иргэдийн улс төрийн оролцоо өргөн байх боломжийг нээсэн байх хэрэгтэй. Ардчилсан улс оронд бүх нийтийн чөлөөт сонгуулиар улс төрийн олон өрсөлдөгчийн дотроос төр барих хүчнийг тодруулдаг. Энэ нь ард түмэн төлөөллийн ардчилалын зарчмын дагуу улстөрд оролцож байгаа оролцооны нэгэн хэлбэр нь юм.

Улс төрийн ухамсар нь иргэдийн улс төрийн бодит харилцааг тусгасан үзэл баримтлал, төсөөлөл, нийгмийн мэдрэмжийг цогцоор нь багтаасан нийгмийн ухамсрын хүрээ. Улс төрийн ухамсар нь нийгэмд зохицуулах чиг үүрэг, танин мэдэхүй мэдээллийн, үнэлэмжийн болон дайчлах, нэгтгэх чиг үүрэг гүйцэтгэдэг. Энэ ч утгаараа иргэдийн улс төрийн оролцоонд ихээхэн нөлөөлдөг билээ. Иргэд сонгуульд оролцон саналаа өгөх нь улс төрийн оролцооны нэгэн чухал хэлбэр байдаг хэдий ч өнөөдөр иргэд татгалзаж эхэлж байгаа нь тэдний сонгуульд оролцох идэвхээс харагдаж байна. Тухайлбал, Монгол Улсад төлөөллийн ардчилалын зарчмын дагуу 1992 оноос хойш Улсын Их Хурлын нийт 7 удаагийн ээлжит сонгууль болсон бөгөөд сонгогчдын оролцоо жилирэх бүр буурсаар байна. Харин 2016 оны сонгуульд иргэдийн оролцоо өссөн хувьтай гарсан. (График №2).

График №2. Улсын Их Хурлын сонгуулийн нэгдсэн дүн. (хувь)

